

ТАРАГТ СУМЫН ЗДТГ-ЫН 1-Р САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2019.01.24

№	Төлөвлөгөө	Биелэлт
Эдийн засгийн салбарт		
1	Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл явуулж тайланг хүргүүлэх	Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг 2018.12.22-2019.01.03-ны өдрүүдэд 6 багийн хэмжээнд зохион байгууллаа. Нийт цэргийн насны 888 иргэн бүртгэлд хамрагдсан.
2	ХАСХОМ бүртгэж баталгаажуулах	2019.01.11-ээс эхлэн 6 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг авч бүртгэсэн.
3	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах Монго	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах МУ-ын Шадар сайдын 120 дугаар тушаалын дагуу зааварчилгааг албан байгууллагуудад танилцууллаа.
4	Сум хөгжүүлэх сангийн тайлан мэдээг явуулах	Аудитын байгууллагаас ирүүлсэн судалгааны маягтын дагуу Сум хөгжүүлэх сангийн 2018 оны жилийн эцсийн үлдэгдэлтэй иргэдийн судалгаа, 2011 оноос хойшхи санхүүжилтын судалгааг гаргаж хүргүүлсэн. Мөн ХХААГазарт сум хөгжүүлэх сангаас зээл авсан 204 иргэний дэлгэрэнгүй болон хураангуй тайланг гаргаж хүргүүлсэн.
5	Үйлдвэрлэл үйлчилгээний судалгааг гаргах	Жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн судалгааг гаргаж ХХААГ-т хүргүүлсэн
6	Аварга тэргүүний шагнал бэлтгэх	Улс, аймаг, сумын нийт 20 аварга тодорсон бөгөөд эдгээр иргэдэд өгөх батламж, дурсамж болон дурсгалын зүйлүүдийг бэлтгэсэн.
7	Наториатын үйл ажиллагааг тогтмол явуулах	Банкнаас зээл авахтай холбогдуулан 49 иргэний баримт бичиг, 33 иргэний зээлийн гэрээнд наториатын баталгаа хийсэн.
8	2018 оны ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэлд Нийтийн сонсгол зохион байгуулах	2018 онд ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэлд нийтийн сонсгол, сургалтыг 2019 оны 1 сарын 21-ны өдөр сумын ЭМТөвд зохион байгуулсан. Нийт 75 төрийн албан хаагчид оролцож өөрсдийн саналаа тусгаж, ОНХСангийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон.
9	2019 онд хийгдэх хэлэлцүүлэг, сургалтын санал авах /Албан байгууллага, Албан хаагчид/	2019 онд хийгдэх хэлэлцүүлэг, сонсголын саналын хуудсыг өгсөн одоогийн байдлаар албан хаагчдийн өгсөн саналыг хүлээн авч, эмхэтгэж байна.
10	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бараа ажил үйлчилгээний худалдан авах үйл ажиллагаанд оролцох	2019 оны 1 сарын 15 өдрөөс эхлэн үнэлгээний хороо байгуулагдаж, тендерийн баримт бичгийг бүрдүүлж, урилгыг сайтад нийтэлж ажилласан.
11	Иргэний танхимын мэдээллийн самбарын	Иргэний танхимын мэдээллийн самбарын хууль тогтоомж, төсөв, санхүү, төлбөр дансны

	мэдээллийг шинэчиллэх	мэдээлэл, мал тооллогын дүн зэргийг байршуулж иргэдийг мэдээллээр хангаж ажилласан.
12	Сумын цахим хуудсанд мэдээлэл бэлтгэн байршуулах	Сумын цахим хуудасны мэдээллийг тухай бүрт шинэчилэн баяжуулж, энэ сард нийт 8 мэдээлэл бэлтгэн байршуулсан байна.
13	Сумын сонины эх хувийг бэлтгэх	2018 оны сумын сонины материалыг албан байгууллага, албан хаагчдаас авч эх бэлтгэлийг ажлыг хийж гүйцэтгэсэн.
14	Нийгмийн даатгалтай холбоотой үйл ажиллагаанд иргэдийг чирэгдүүлэхгүй түргэн шуурхай холбон өгч ажиллах	Нийгмийн даатгалын байцаагчийн ажлыг түр гүйцэтгэж нийгмийн даатгалын хууль тогтоомж, шимтгэлийн өөрчлөлтийг танилцуулж нийт 58 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлсэн.
15	Иргэний танхимын үйлчилгээ	Энэ сард иргэний танхимаар 71 иргэн хууль тогтоомжийн талаар, өргөдлийн загварын талаарх, баримт бичиг хувилуулах зэргээр үйлчлүүлсэн байна.
16	Санал асуулга авах	Зорилтод өрхүүдээс санал асуулгыг боловсруулж, 9 иргэнээс авч үр дүнг тооцсон.
17	Ирсэн, явсан бичиг, захирамж, тушаалын бүртгэлийн дэвтэр, бланк тоотын захиалга өгөх	Ирсэн, явуулсан бичиг 2, захирамж тушаалын бүртгэлийн дэвтэр, мөн 1,3-р багийн Засаг даргын тоотуудын захиалан авчруулсан.
18	ХШҮнэлгээний шалгалтанд бэлтгэх	Өөрийн ажлын холбогдолтой аймгийн Засаг даргын 02-р албан даалгаврын хэрэгжилт, аймаг, сумын үндсэн чиглэлийн биелэлт, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтүүдийг гаргаж Төрийн захиргааны ажилтанд өгсөн.
19	Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг бүх төсөвт байгууллагуудаар шивж дуусган тушаах	ТАХаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг 2019-01-07-ны өдөр хүлээлгэн өгсөн. ТАХаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг бүх төсөвт байгууллагуудаар хэвлэн авч хадгалсан.
20	2019 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн баримт материалыг шивж дуусган хүлээлгэн өгөх	2019 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг хугацаанд нь явуулан Тамгын газрын даргын хамт цэргийн штабт хүлээлгэн өгсөн.
21	Ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдлыг тухай бүр бүртгэж авч Засаг даргад танилцуулах	Ирсэн бичиг 10, явуулсан Засаг даргын 10, Тамгын даргын 20, өргөдөл гомдол 2-ийг "ORG-RMS" программ ашиглан бүртгээд байна.
22	Хариутай албан бичгийг тухай бүр шаардан авч хугацаанд нь явуулах	2019 он гарсаар 10 албан бичиг ирсэнээс хариутай 9, хариугүй, 5 албан бичгийг хугацаанд нь явуулаад байна
23	Багийн Засаг дарга нарт хэвлэмэл хуудсыг дугаарлаж өгөх	1-р багийн Засаг даргад 125, 2-р багийн Засаг даргад 57, 3-р багийн Засаг даргад 125, 4-р багийн Засаг даргад 76, 5-р багийн Засаг даргад

		80, 6-р багийн Засаг даргад 70 бланк тоотуудыг дугаарлан өгч, гарын үсэг зуруулаад байна.
24	ЗДТГ-ын ажилтнуудаас ХХНЖагсаалтын дагуу хүлээн авч архивлах	ХХНЖагсаалтыг хэвлэн авч дундын группт тавьсан. 1 дэх өдрийн ажилтнуудын цуглаанаар хүн тус бүрэр танилцуулсан.
25	Төсөвт байгууллага болох ЕБС, СӨББ, ЭМТөв, Соёлын төв зээг байгууллагуудын 2018 оны архивлах баримтыг үзэж заавар зөвлөгөө өгөх	СӨББ-ийн архив хариуцсан ажилтанд заавар зөвлөгөө өгсөн.
26	Ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдлын бүртгэлийг “ORG-RMS “ программ ашиглан тогтмол хөтлөх	Ирсэн бичиг 10, явуулсан Засаг даргын 10, Тамгын даргын 20, өргөдөл гомдол 2-ийг “ORG-RMS “ программ ашиглан бүртгээд байна.
27	2018 оны Засаг даргын захирамж, тамгын газрын даргын тушаалуудыг скайнердаж мастер хувьтай болох	2018 оны Тамгын газрын даргын тушаал /үйл ажиллагаа 18, боловсон хүчний 9 тушаалыг скайнердан мастер хувьтай болгоод байна.
28	Аймгийн Засаг даргын 02 дугаар албан даалгаврын биелэлтийг гаргах	Аймгийн Засаг даргын 02 дугаар албан даалгаврын биелэлтийг гаргасан.
29	Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг бүртгэх	сар бүрийн 7 хоногийн Даваа гарагт иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг бүртгэн бүртгэлийн дараалалд оруулан хүргүүллээ.
30	Хувь хүний хөрөнгө орлогын мэдүүлэг хийх	2018 оныХувьхүнийхөрөнгө орлогын мэдүүлгийг шивж оруулж баталгаажууллаа.
31	Урд оны бичиг баримтуудыг цэгцлэх	Иргэний 8н төрлийн бүртгэлийн дэвтрүүдийг хуудас тус бүрээр нь стандарт болгон цэгцэлж жагсаалт үйлдэн аймгийн улсын бүртгэлийн архивын ажилтанд хүлээлгэн өглөө.
32	Иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх	Энэ сард шинэ төрсөн хүүхэд 4 үүнээс эрэгтэй 2, эмэгтэй 2, овог нэр, нэр өөрчилсний бүртгэл1, нас барсны бүртгэл 1, 16 нас хүрч иргэний үнэмлэхээ захиалсан 3, 25,45 насны сунгалтаа хийлгэхээр бүртгүүлсэн 9 иргэн баг хоорондын шилжилт хөдөлгөөн хийлгэсэн. нийт 2 иргэний бүртгэл бүртгэн нийт 18 иргэний бүртгэлийг бүртгэл мэдээллийн санд баталгаажууллаа.
33	Энэ онд 16 нас хүрч шинээр 25,45 насны сунгалтаа хийлгэх иргэдийн судалгааг гаргах	ХАМС-ийн мэдээллийн санд байгаа хүн амаас 16, 25,45 насны сунгалт хийлгэх иргэдийн судалгааг баг тус бүрээр гарган авч багийн засаг дарга нарт хүргүүллээ.
34	Бусад ажил	Арвайхээр сумын төрийн үйлчилгээний төв дээр очиж аймгийн иргэдэд 3 хоног бүртгэлийн ажлыг хийн ажиллаа. Мөн сумын сонинд холбогдох

		материалыг гаргаж өглөө.
Төсөв санхүүгийн чиглэлээр		
35	Соёлын төвийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх /1 газар, 1 барилга, 1 нийтийн эзэмшил/	Соёлын төвийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэн 2019.01.09-2019.01.10-ны өдрүүдэд ММҮИ-ээс томилогдсон үнэлгээчинд шалгуулсан. Үнэлгээгээр 7158000 төгрөгийн газар, 20784000 төгрөгийн барилга, 3336450 төгрөгийн нийтийн эзэмшилийн хашааг үнэлж бүртгэсэн.
36	Соёлын төвийн санхүүгийн тайлан гаргах, няравын тайланг хянах, баталгаажуулах	Соёлын төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг дуусгаж 2019.01.07нд төрийн аудитаар орсон. Мөн санхүүгийн тайлангийн е-баланс цахимаар шивж илгээсэн.
37	Нийгмийн даатгалын 12 сарын тайлан, ЗДТГ, ИТХ, Соёлын төвийн 12 сарын байгууллагын өр авлагын мэдээ, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, нэмэлт санхүүжилтийн мэдээнүүдийг гаргаж холбогдох байгууллага, мэргэжилтэнд өгөх, файлаар илгээх, баталгаажуулах	ЗДТГазар, Соёлын төв, ИТХ-ын НДШ-ийн тайланг шивж илгээн, цаасаар хэвлэн баталгаажуулж тооцоо нийлж акт үйлдсэн. Мөн хариуцсан 3 байгууллагын жилийн эцсийн үндсэн санхүүжилт болон нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээг 2019.01.05-ны дотор гарган төрийн сангийн мэргэжилтнээр баталгаажуулуулсан.
38	ЗДТГазар, ИТХурал, Соёлын төвийн албан хаагчдын эд хариуцагчийн картыг хүн тус бүрээр гаргаж няравт өгч албан хаагчидтай гэрээ хийх	ЗДТГазар, ИТХурал, Соёлын төвийн ажилтан, албан хаагчдын эд хариуцагчийн картыг хүн бүрээр гаргаж няравт файлаар өгсөн.
39	Соёлын төвийн санхүүгийн тайлан аудитад оруулах	Соёлын төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг дуусгаж 2019.01.07нд төрийн аудитаар орсон. Аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан.
40	ЗДТГазар, ИТХурал, Соёлын төвийн шилэн дансны мэдээллийг тухай бүр, сар, улирал, жилээр оруулах	ЗДТГазар, ИТХурал, Соёлын төвийн шилэн дансны мэдээллийг тухай бүр, сар бүр, улиралд оруулах мэдээллүүдийг бүрэн оруулж бүтэн жилээр оруулах мэдээллийн холбогдох мэдээллийг бүрэн оруулсан. Соёлын өв бүтэн жилийн байдлаар хугацаандаа оруулсан мэдээлэл 141, хугацаа хоцорсон 1, ИТХурал хугацаандаа оруулсан 143, хугацаа хоцорсон 1, ЗДТГазар хугацаандаа оруулсан 144, хугацаа хоцорсон 1, нийт 431 мэдээлэл байршуулсан байна.
41	ЗДТГазрын үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх / 10 газар, 26 барилга, байгууламж/	ЗДТГазрын үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг төрийн сангийн мэргэжилтэн Б.Ундрахтай хамтарч үнэлэх ажлыг эхний байдлаар хийж ММҮИ-ээс томилогдсон үнэлэгээчнээр хянуулж зөвлөгөө авсан. Үнэлгээний ажлын хураангуй

		тайлан 30 хувийн гүйцэтгэлтэй хараахан дуусах болоогүй байна. Үнэлгээнд 10 газар, 1 холбооны шугам, 10 нийтийн эзэмшил, 12 барилга тус тус хамрагдаад байна.
42	Дахин үнэлгээний тайланг дуусгаж ОНӨГазарт нэгтгүүлэх	Дахин үнэлгээний тайланг нэгтгүүлэх ажил хойшлогдсон. Аймгийн ОНӨГазраас ирсэн хуваарийн дагуу нэгтгүүлнэ.
43	ЗДТГ-ын санхүүгийн тайлан гаргах	ЗДТГ-ын санхүүгийн тайлан 90 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Няравтай хамтарч бараа материалын тайлангаа нийлж дууссан ч дахин үнэлгээний ажлаас болж хөрөнгүүдийн дүнд өөрчлөлт орж магадгүй учир тайлан хараахан дуусаагүй байна.
44	ЗДТГазар, ИТХурал, Соёлын төвийн ХХОАТ-ын тайлан, Суутганы тайлан, ТТАМНАТөлбөрийн тайланг 2018 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр тайлагнаж, тооцоо нийлэх	ЗДТГазар, Соёлын төв, ИТХурлын 2018 оны жилийн эцсийн суутган, ХХОАТ-ын тайлан, ТТАМНАТөлбөрийн тайлан, газрын төлбөрийн тайланг эцэслэн гаргаж илгээсэн. Мөн байгууллага бүрээр Татварын хэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулсан.
45	ЗДТГ-ын санхүүгийн тайланг аудитад оруулах	ЗДТГ-ын санхүүгийн тайланг аудитад оруулах ажил түр хойшилсон. Учир нь дахин үнэлгээний нягтлан шалгалтын тайлангаар зарим хөрөнгийн үнийн дүнд өөрчлөлт орж магадгүй учир түр хойшлуулсан.
46	ЗДТГазар, ИТХурал, Соёлын төвийн 1 сарын цалин, тогтмол болон хувьсах зардал бусад зардлын гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн хийх	ЗДТГазар, ИТХурал, Соёлын төвийн зарцуулах эрх нээгдсэн ч санхүүжилт хараахан орж ирээгүй байна.
47	ИТХ-ын санхүүгийн тайланг гаргах	ИТХ-ын жилийн эцсийн санхүүгийн тайланг хийж дуусган, архивт өгөх баримтаа бэлдэж үдэж цэгцэлсэн.
48	2019 оны Орон нутгийн байгууллагын төсөв, ОНХСан, СХСангийн төлөвлөгөөг Төсвийн төлөвлөлтийн програмд хязгаар үүсгэн шивэх	2019 оны Орон нутгийн байгууллагын төсөв, ОНХСан, СХСангийн төлөвлөгөөг Төсвийн төлөвлөлтийн програмд хязгаар үүсгэн шивэлт хийгдэж илгээгдсэн. Байгууллагуудын сарчилсан хуваарийг СТСангийн хэлтэсээс батласаны дараа шивэгдэхээр болсон
49	Сумын ИТХурлаар 2018 оны төсвийн гүйцэтгэл хэлэлцүүлэх	ИТХурлын тов хойшлогдсон.
50	Аймгийн Засаг даргын 02 албан даалгаврын биелэлт	Бүх төсөвт байгууллагуудаас биелэлтийг авч, сумын хэмжээнд нэгтгэн 01 сарын 15-нд илгээсэн.
51	Шилэн дансны 4-р улирлын тайлан илгээлт	Төсвийн байгууллага 8, Орон нутгийн өмчийн газар 1 байгууллагын шилэн дансны тайланг

		шалгаж хүлээн авсан. Шилэн дансны тайлан илгээлтийг 01 сарын 14-нд илгээсэн
52	Шилэн дансны 12, 1 дүгээр сарын мэдээлэл байршуулах	
53	2018 оны Худалдан авах ажиллагааны тайлан гаргаж, холбогдох хэлтсүүдэд хүргүүлэх	2018 оны Худалдан авах ажиллагааны тайланг 1 сарын 4-нд Орон нутгийн өмчийн газар Худалдан авах ажиллагааны хэлтэст, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. Сумын вэб сайт, мэдээллийн самбарт байршуулсан.
54	2019 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулах, www.tender.gov.mn сайтад байршуулах	2019 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гарган, сумын вэб сайт, цахим тендер, мэдээллийн самбарт байршуулсан. Нийт 174606,1 мянган төгрөгний 12 тендер үүнээс Харьцуулалтын аргаар 8 тендер, Олон нийтийн оролцооны аргаар 4 тендер зарлагдахаар төлөвлөгдлөө.
55	Төрийн сангийн тамга, тэмдгийн бүртгэл, эрсдлийн үнэлгээний судалгаа гаргах	Санхүү төрийн сангийн хэлтэст 1 сарын 4-нд төрийн сангийн тамга, тэмдгийн судалгаа, эрсдлийн үнэлгээний судалгааг хүргүүлээ.
56	Төсөвт байгууллагуудын Хоол, Үдийн цай, шатахууны тендер зарлах, цахимаар явуулах	ЕБСургуулийн хоол 34866,1 мянган төгрөг, Үдийн цай 10605,0 мянган төгрөг, Туяа багийн ЕБСургууль Үдийн цай 3177,0 мянган төгрөг, хоол 17080,1 мянган төгрөг, СӨББайгууллагын хоол 23661,0 мянган төгрөг, ЭМТөвийн шатахуун 5566,0 мянган төгрөгөөр цахим тендер зарлагдсан. Үнийн урилгыг 1 сарын 23-нд нийтлэсэн.
57	2018 оны гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт, 2019 оны төлөвлөгөө батлуулах	2018 оны гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтийг Шилэн данс, Аудитын жилийн гүйцэтгэлээр гаргасан. 2019 онд Шилэн дансны хэрэгжилт, ОНХСангийн гүйцэтгэл сайжруулах, Аудитын жилийн гүйцэтгэл, Төрийн сангийн дотоод хяналтын төлөвлөгөөг батлуулсан.
58	Төрийн сангийн өдөр тутмын үйл ажиллагаа, дансны үлдэгдлийн баталгаа, гарын үсгийн баталгаа	Төрийн сангийн Freebalance програмаар Төрийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулж байна. Орон нутгийн ерөнхий орлого, Төрийн сангийн Орлогууд, ОНХСан, СХСангийн дансны үлдэгдлийн баталгаа, гарын үсгийн баталгааг гаргаж, 2019 онд гүйлгээ хийх эрхээ баталгаажууллаа.
59	Төсөвт байгууллагуудын /Соёлын төв, ИТХурал, ЗДТГазар/ 2018 оны жилийн эцсийн тайлан гаргалтанд хяналт тавих	Соёлын төвийн 2018 оны жилийн эцсийн тайланг хянасан. ЗДТГазар, ИТХурлын тайлан гарч дуусаагүй байна.
60	ОНЕорлого, СХСан, ОНХСангийн сарын мэдээ, ЗЭБаталгаа	2018 оны жилийн эцсийн байдлаарх ОНЕОрлого, СХСан, ОНХСангийн сарын мэдээ, Зарцуулалтын эрхийн баталгааг гарган ажилласан.

61	Статистикийн мэдээлэл гаргах, аж ахуй нэгж иргэдэд статистик мэдээллээр хангах	Статистикийн 2018 оны жилийн эцсийн мэдээллүүдийг эцэслэсэн. Нийт 11хүнд 22 мэдээлэл гаргаж өгч мэдээллээр хангасан.
62	2018 оны жилийн эцсийн хяналт, шинжилгээ үнэлгээний тайланд холбогдох материалуудыг гаргаж өгөх	Холбогдох материалуудыг гаргаж өгсөн.
63	Сумын вэб сайтанд байршуулах мэдээллийг гаргаж, мэдээллэх	Сумын вэб сайтанд ХАА-ны төлөвлөгөө, Тайлан, Тогтоол, Тендерийн урилгуудыг гаргаж өгч мэдээллэсэн.
64	Татварын орлогын биелэлтийг хангахад анхаарах	Татварын орлого ХАОАТ 10,0, Тэмдэгтийн хураамж 62,2 Буу 30,0 Торгууль 400,0 Хадгаламжийн хүү 820,8 нийт 1333,1 мянган төгрөг орсон.
65	Шинээр хийсэн ажил	Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний дагуу ажилтан Э. Есөн-Эрдэнэ Ж. Долгорсүрэн нартай хамтран ОНХСангийн 2018 оны гүйцэтгэлээр Нийтийн сонсгол зохион байгуулсан. ОНХСангийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хийх ажлуудыг танилцуулсан. ОНХСангийнНийтийн сонсголд нийт 42 иргэн оролцсон. 2020 онд хэрэгжүүлэх ОНХСангийн санал асуулгын мэдээллийг авлаа.
66	2018 оны 10,11,12 сарын нябо журналыг боловсруулж мемориалын баримт үүсгэх. Жилийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, ЗЭБаталгааг үдэж архивын нэгж үүсгэх.	2018 оны 10,11,12 сарын төрийн сангийн баримтыг нябо журналаар боловсруулж мемориалын баримт үүсгэж архивт өгөхөд бэлэн болсон.
67	Төсөвт байгууллагуудын гарын үсгийн баталгаа, Дансны үлдэгдийн баталгааг авах	Сургууль, Цэцэрлэг хоёр байгууллагаас бусад нь өгсөн байгаа.
68	Байгууллагуудын ЗЭБаталгааг авч зардал зүйл ангийн дагуу зарлагын гүйлгээг шивэх	Төсвийн зарлагыг байгууллагын дарга нягтлан бодогчийн буюу 1 болон 2 дугаар гарын үсгээр баталгаажсан төлбөрийн хүсэлтийг ЗЭБ маягтын дагуу Freebalance программаар хийж байна. Сар бүрийн санхүүжилтийг зарцуулахдаа : <ol style="list-style-type: none"> 1. Ажиллагсадын цалин 2. НДШ 3. Цалингаас суутгасан орлогын албан татварууд 4. Тогтмол зардлууд Бусад зайлашгүй зардлыг санхүүжүүлэх гэсэн төлбөрийн дарааллыг мөрдөж байна
69	Төсөвт байгууллагуудын	Төсөвт байгууллагуудын хөрөнгөтэй холбоотой

	хөрөнгө оруулалт, данс хооронд шилжүүлсэн хөрөнгийн жагсаалт, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланг байгууллагын дарга эрхлэгч нарын тушаалын хамт авч нэгтгэх	бичиг баримтыг авч нэгтгэхэд ЗДТГазар, Соёлын төв дээр данс хооронд шилжүүлсэн хөрөнгө гарсан. Мөн хөрөнгө оруулалт дээр байгууллага тус бүрээс авч нэгтгэн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулсан байгаа сумын хэмжээнд нийт 226,517,905 төгрөгний хөрөнгө оруулалтыг хандив тусламж, ОНХСан, Төсөл хөтөлбөр, Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн байна.
70	ИТХурлын нарийн бичгийн даргатай аймгийн ИТХ-д өмч эзэмшлийн гэрээг холбогдох бичиг баримтын хамт авч очиж дүгнүүлэх	2019 оны 01 сарын 09-10-ны хооронд ОНӨГазарт очиж сургалтанд сууж өмч эзэмшлийн гэрээг ИТХурал 90.74%, ЗДТГазар 90.92%, ЕБС 88.85%, Цэцэрлэг 88.85%, Туяа багийн ЕБС 90%, Соёлын төв 90.23%, ЭМТөв 90.23% тус тус дүгнүүлсэн. Сумын дундаж 89.97%.
71	Төсөвт байгууллагуудын дахин үнэлгээг зохион байгуулж хамтран ажиллах	2019 оны 01 сарын 09 нд Нягтлан шалгалтын үнэлгээчнээр хийсэн үнэлгээгээ хянуулсан. Засах шаардлагтай зүйл гарч ирсэн байгаа бичилт ихтэй учраас хураангуй тайланг бичиж дуусаагүй байна. Мөн бусад хавсралт баримтуудыг бүрдүүлж 25-ны дотор дуусгасан байна.
72	Орон нутгийн өмчийн газарт тайлан өгөхөд бэлтгэх	Аймгийн ОНӨГазраас тайлан өгөх хуваарь ирээгүй байгаа.
73	2018 оны бичиг баримтаа нягтлантай хамтарч дахин нягтлан тулгаж аудитад бэлтгэх	2018 онд ЗДТГазар шатахуун 01-06 сараар ,07-12 сар болгон хоёр хувааж үдсэн. Аж ахуй, бичиг хэрэг, барилгын засварын материал, сэлбэг хэрэгсэл, үндсэн хөрөнгө, тооллогын бүртгэл зэргийг багцлан үдэж аудитад оруулахад бэлэн болгож архивлалаа. ИТХурал шатахуун, бичиг хэрэг, аж ахуй, сэлбэг хэрэгсэл, барилгын засвар, үндсэн хөрөнгө, тооллогын бүртгэл зэргийг тус бүрд нь багцлан үдэж архивлалаа.
74	Үндсэн хөрөнгө, бичиг хэрэг, бараа материал, шатахууны орлого зэргийн анхан шатны бичиг баримтыг бүрдүүлж тайлан гаргаж нягтланд тайлагнах.	ЗДТГазар энэ сард 116600 төгрөгний бичиг хэрэг, ИТХурал 33000 төгрөгний бичиг хэрэг, шатахуун тооцоо хийлээгүй байна баян арвайн талын нэхэмжлэх ирээгүй.
75	Банкнаас татан авсан бэлэг мөнгөний зарлагын гүйлгээг хийж тайлагнах.	Сарын гүйлгээ хийгдээгүй байгаа болхоор бэлэн мөнгөний тайлан сарын сүүлийн өдөр гарна.
76	Цэвэрлэгээгээ хуваарийн дагуу тогтмол хийх.	Цэвэрлэгээгээ хуваарийн дагуу хийсэн
77	Ажилчин албан хаагчдын нэр дээрх эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг	Урд оны баримтыг янзлаад гэрээгээ хийж амжсангүй


	шинэчлэн байгуулах.	
78	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь биелүүлэх	Сумын төвд гэрэл цахилгаангүй нэг айл байдаг тэр айлд гэрэл тавиулав.
79	Цагийн баланс гаргах	Ажилчдын цагийг цагийн бүртгэлээс хэвлэн гаргаж цагийн баланс гаргана.
Хөдөө аж ахуйн чиглэлээр		
80	Улс, аймгийн аварга малчдын материалыг бүрдүүлж, ХХААГ-т хүлээлгэн өгөх	2018-12-25 ны дотор улсын сайн малчнаар 1-р багийн малчин Г.Тогоотөмөр, 2019-01-05 ны дотор “Алтан унаганы эзэн-ээр Ж.Бат-Очир-ын баримт материалыг “Улсын аварга малчин”, “Алтан төлийн эзэн” шалгаруулах журмын дагуу бүрдүүлэн хугацаанд нь явуулсан.Үр дүн: 1 Улсын аварга малчин, Алтан унаганы эзэн-ээр 1 малчин шалгарлаа.
81	2017 оны арьс шир түүхий эдийн урамшуулалд хамрагдаж байгаа малчдын баримтны алдааг засах, илгээх	Урамшуулалд хамрагдсан тушаал нь гарсан 154 малчны РД алдаа, данс хаагдсан, зөрсөн алдааг нэг бүрчлэн банк, иргэний бүртгэлтэй тулгалт хийж аймгийн ХХААГ-д илгээн алдааг засвар оруулан Мал хамгаалах санд илгээсэн байна.
82	2018 оны түүхий эдийн падааныг малчдаас хүлээн авч, программд шивж оруулан баримт бичгийн ХХААГ-т хүлээлгэн өгөх	904 ширхэг падааныг малчдаас хүлээн авч шивэлтэнд оруулан, программд татсан.Алдааг тулгалт хийсэн.Эцсийн байдлаар хүлээлгэж өгөөгүй байна.
83	Үр дүнгийн гэрээ, жилийн ажлын төлөвлөгөө гаргах	Жилийн ажлын төлөвлөгөөгөө боловсруулж байна.
84	Хөтөлбөрүүдийн төлөвлөгөө гаргах	Хөтөлбөрүүдийн тайлан гаргаж ЗДО-д хүлээлгэн өгсөн.Энэ оны хөтөлбөрүүдийн төлөвлөгөөг боловсруулж байна.
85	Хугацаатай мэдээ тайлан гаргах	1 хугацаатай бичиг ирсэний дагуу гахайны аж ахуй эрхэлж байгаа Д.Өлзийбаярын гахайнд үзлэг шинжилгээ, ариутгал халдваргүйжүүлэлт хийж илтгэх хуудсыг хугацаанд нь аймгийн МЭГ-т хүргүүлсэн.
86	Улсын хөрөнгөөр инженерийн хийцтэй худаг шинээр гаргах	Улсын төсвийн хөрөнгөөр инженерийн хийцтэй худаг шинээр гаргах худагны судалгааг багийн дарга нараас авч нийт 1-р багаас 3 худаг, 5-р багаас 1 худаг, 2-р багаас 1 худагны судлагаа авч нийт 5 худаг шинээр гаргах захиалга явуулсан.
87	Инженерийн хийцтэй худаг сэргээн засварлах	Инженерийн хийцтэй худаг сэргээн засварлах худагны судалгааг багийн дарга нараас авсан.Суманд худаг сэргээн засварлахаар 4-р баг 1 худаг ,5-р баг 3 худаг, 2-р баг 1 худаг 3-р баг 1 худаг нийт 6 худаг сэргээн засварлах захиалга ХХААГ-т явуулсан
88	Эрчимжсэн аж ахуйн судалгааг шинээр	Гахайн аж ахуй 1 ,шувууны аж ахуй 1, сүүний үхэр 32,мах сүүний үхэр 208, махны чиглэлийн

	гаргах	хонь 305 байна
89	Гахайн Мязан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Малын эмч Д.Баяржаргалаар Гахайн аж ахуйтай Өлзийбаярын гахайд үзлэг хийх болон байр саравч ариутгах ,хоол тэжээлд хяналт тавих, тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж өгүүлсэн.
Газар зохион байгуулалт, байгаль орчны чиглэлээр		
90	2019 оны ГЗБТөлөвлөгөөнд тусгагдсан дуудлага худалдааны зар мэдээг олон нийтэд нээлттэй байршуулах ажлыг зохион байгуулах	Дуудлага худалдааны зарыг энэ сард тавихаар төлөвлөж байсан боловч Дуудлага худалдааны зохион байгуулах хугацаа сар шиний баяртай давхцахаар болсон тул хойшлогдсон.
91	Газрын эрх нь үүссэн иргэдийг гэрээ, гэрчилгээжүүлэх ажлыг хийж гүйцэтгэх	3 ААНБ, 2 иргэний материал бүрдүүлэн ЛМ програмаас УБХэлтэсрүү илгээж хянуулан Э-дугаар авч 2 иргэнд гэрчилгээ бичиж өгсөн.
92	ЛМ програмд суурилсан нөхөн бүрдүүлэлтийг өдөр тутамдаа хийж гүйцэтгэх	ЛМ програм өдөр тутам шинэчлэгдэж байгаатай холбогдуулан програмын шинэчилсэн хувилбарыг тухай бүр нь суулгаж байна. Нөхөн бүрдүүлэлтийн ажил өдөр тутам хийгдэж байна.
93	Бусад нэмэлтээр хийсэн ажил	ГХБХБГ-т хувийн хэрэг, кадастрийн үнэт цаасны орлого, зарлагын үлдэгдлийн тайланг гарган хүргүүлсэн.
94		Сонинд тавиулах материалыг иргэний танхимын ажилтанд өгсөн.
95		2018 оны газрын төлбөрийн ГТМ-8 тайланг эцсийн байдлаар гарган ГХБХБГ-т хүргүүлсэн. Газрын үнэлгээ, төлбөрийн хэмжээ бүсчлэл шинчлэн тогтоох хэм, хэмжээ тогтоосон актыг өөрийн биеээр боловсруулан ИТХуралд танилцуулан батлуулж Хууль зүйн яамруу явуулсан. Дээрх актын хариу 2019.01.03-нд Хууль зүйн яамнаас Улсын нэгдсэн бүртгэлийн 4122 дугаарт бүртэгснийг мэдэгдсэн МУ-ын ХЗДХСайд Ц.Нямдоржийн гарын үсэгтэй тоотын хамт баталгаажиж ирсэн. Энэхүү акт баталгаажиж ирсэнтэй холбогдуудлан 2019 оноос эхлэн газрын төлбөрийн хэмжээ тус тогтоолын дагуу тооцогдон явагдаж байна.
96		Дээрх үнэлгээний бүсчлэлийг зурагллыг гарган ГХБХБГ-т хүргүүлэн ЛМ програм үнэлгээний бүсчлэл оруулан шинчлэл хийгдсэн.
97		2019 оны ГЗБТөлөвлөгөөнд тусгуулахаар хүсэлт ирүүлсэн иргэний хүсэлт ИТХ-аар дэмжигдээгүй тухай хариуг утсаар мэдэгдсэн. Мөн 6 иргэний 2019 оны ГЗБТөлөвлөгөөнд тусгуулах газрын хүсэлт ирсэн нь төлөвлөгөө батлагдсний дараа ирсэн тул шийдвэрлэх боломжгүй талаар утсаар мэдэгдсэн болно.
98		4ш газрын гэрчилгээ барьцаалсан тухай бүртгэл

		бүргэсэн.
99		Аймгийн цагдаагийн газраас зохион байгуулж бу сумын бүх иргэн, ААНБ-ын хаяг, байршил, тухай иргэн хуулийн этгээдтэй холбоотой мэдээллийн са үүсгэхтэй холбогдуулан 6-н багийн хилийг QGIS програмаас Google Earth-рүү хөрвүүлэн сумь цагдаагын компьютерт суулгаж өгсөн.
100		3 иргэнд утсаар газар эзэмших, өмчлөх талаар зөвөлгөө өгсөн байна. 1 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх захирамж гаргасан.
101	Агаар бохирдуулагчийн эх үүсгэврийн судалгааг шинэчилэн хүргүүлэх	Агаар бохирдуулагчийн эх үүсгэврийн судалгааг шинэчилэн гаргаж Аймгийн УЦУОШГазарт хүргүүлсэн мөн Аймгийн МХГазраас ирсэн агаар бохирдуулагчийн судалгааг ирсэн хавсралтын дагуу гаргаж хүргүүлсэн
102	Уламжлалт сар шиний баярыг тохиолдуулан бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах	Уламжилалт сар шиний баярыг тохиолдуулан гудамж хорооллоор явж албан мэдэгдэл тараан ажиллаж байна. Нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулхаар төлөвлөөд байсан ч ирт учираас 1-р сарын 31-ээс 2-сарын 1-2-нд зохион байгуулхаар болоод байна
103	Зорилтот жилийн төлөвлөгөөг боловсруулж ИТХуралд танилцуулах	Зорилтот жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд албан газруудад ЗДТГазрын Албан тоот тарааж Албан тоодын дагуу ирсэн байгууллагын төлөвлөгөөг нэгдгэж байна
104	Нохой устгалын ажлыг зохион байгуулах	Нохой устгалын ажлыг санхүүжил орж ирхээр хийнэ устгах хүнээ орцон байга
105	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар	<ul style="list-style-type: none"> ✓ 2019 оны ХАСХОМ-г гаргаж өгсөн ✓ Аймгийн ХБХэлтэст зорилтод жилийн саналаа өгч мөн дэмжлэг авах 1 ажлын саналаа ЗДТГазрын албан тоотоор хүргүүлсэн ✓ Бохирын цооногтой болон цооноггүй нохойтой болон нохойгүй айлуудын судалгааг гаргаж байна ✓ ХШҮнэлгээнд шаардагдах өөрийн холбогдолтой мэдээ тайланг гарган өгсөн.
Нийгмийн даатгал, халамжийн чиглэлээр		
106	Иргэдийн өгсөн өргөдөл, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж, хувийн хэрэг бүрдүүлэн ажиллах	Цалинтай ээж, жирэмсний тэтгэмж, хүүхдийн мөнгөнд хамрагдах хүсэлтэй иргэдийн материал бүрдүүлж шивэн холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлсэн. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр заалтыг хэрэгжүүлэх ажлын дагуу гаргасан удирдамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж судалгаа, үйл ажиллагааг холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.
107	Амьжиргаа дамжих зөвлөлийн хурлыг 2-оос доошгүй удаа хийх	Халамжийн тухай хуулийн дагуу амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлыг хоёр удаа зохион байгуулж хүнсний эрхийн бичигт орохыг хүссэн өргөдөл 1, асаргааны сунгалт 6 хүн дээр

		хэлэлцсэн.
108	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа, ахмад настны судалгааг гаргаж аймгийн ХХҮГ-т хүргүүлэх	Харьяалалгүй ахмад настны судалгааг багийн засаг дарга нараас авч нэгтгэн 01 сарын 15-нд Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдах 20 өрхийн жагсаалт гаргаж, ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулан судалгаа авч ажиллаж байна.
109	Өрхийн мэдээллийн нэгдсэн судалгаанд хамрагдаагүй өрхүүдийг ахин судалгаанд хамруулах	Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг нэг өрхөөс авч дээд газарт уламжилсан.
110	Хүнсний эрхийн бичиг олгох үйл ажиллагааг зохион байгуулах	Хүнсний эрхийн бичиг олгох ажлыг зохион байгуулж тус хөтөлбөрт хамрагддаг 26 өрхөөс 25 өрхөд олгож, нэг өрх хассан.
111	Нийгмийн даатгалын сангийн орлого:	Нийгмийн даатгалын сайн дурын орлого 41 даатгуулагч 5751.1 мянган төгрөг Эрүүл мэндийн даатгалын орлого 29 даатгуулагч 1055.5 Бүгд 70 даатгуулагч 6806.6 мянган төгрөгний орлого оров.
112	Тэтгэвэр тэтгэмжийг хуулийн дагуу олгох	403 тэтгэвэр авагчдад 115429.1 мянган төгрөг 2 даатгуулагчдад жирэмсэн амаржсаны тэтгэмж-1740.5 мянган төгрөг Оршуулгын тэтгэмж 1 ахмадад 1000000 Бүгд 406 хүнд 118169.5 мянган төгрөг зарцууллаа.
113	Нийгмийн даатгалын холбогдолтой ажил үйлчилгээг үзүүлж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах	<ul style="list-style-type: none"> Сайн дурын даатгуулагч, ажил олгогч байгууллагын даатгуулагч нарын 84 нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн даатгалын дэвтрүүд баталгаажуулав. 2018 онд малчнаар тэтгэвэр тогтоолгосон тэтгэврийн хувийн хэрэг 29 тэтгэвэр авагчийн жагсаалт гаргаж нийгмийн даатгалын хэлтэст явуулав. Тахир дутуугийн тэтгэвэрт орох 1 хүний бичиг баримтыг шалгаж хувийн хэрэг нээн НДХэлтэст явуулав. Тэтгэврийн анхан шатны маягтуудыг хэвлэн гаргаж хөтлөв. Ерөнхий сан, ЭМД-н сангуудын 1-р сарын гүйлгээнүүдийг шивэв. Тэтгэвэрт орохоор дөхөж байгаа 8 иргэдийн бичиг баримтуудыг үзэж зөвлөгөө өгөв.
114	Хүрэмт багийн төвд амьдардаг эрсдэлтэй бүлгийн өрхүүдээр айлчлах	2019-01-11нд Хүрэмт багийн дарга Д.Баасандоржийн хамт эрсдэлтэй нөхцөлд амьдардаг 9 өрхөөр айлчилж үнэлгээ хийсэн. Үнэлгээнээс харахад

		<ul style="list-style-type: none"> • иргэдийн өрхийн орлого тогтмол биш • эрсдэлтэй нөхцөлд мөнгө олдог /гар аргаар алт олборлодог 2 өрх/ • гэр бүлийн гишүүн хол газар ажил хийснээс гэр бүлийн гишүүдийн харилцаа хөндийрч байна. • Хүнсний талонд хамрагдсан нь өрхүүдийн амьжиргааг дэмжих томоохон тусламж болдог. <p>Мөн айлчилсан өрхүүдээс хүүхэд хамгааллын талаарх санал асуулга авлаа. Нийт 6 иргэн санал асуулга өгсний дийлэнх нь хүүхэд хамгааллын талаарх мэдлэгтэй ч цаашид эцэг эхчүүдэд чиглэсэн сургалт, үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, давталттайгаар тогтмол явуулах шаардлагатай нь харагдсан.</p> <p>Санал өгсөн иргэд дараах зүйлсийг бичжээ.</p> <p>-архинаас гаргах сургалт, эмчилгээ</p> <p>-хүүхдийн тоглох орчин аюулгүй байлгах</p> <p>-хүүхдийн хүмүүжлийн талаарх сургалт хийх</p>
115	Хүүхэд, гэр бүлийн дэлгэрэнгүй судалгааны маягтыг бэлтгэн багийн дарга нарт өгөх	6 нэр төрлийн судалгааг бэлтгэн багийн засаг дарга нарт хүргүүлсэн бөгөөд одоогийн байдлаар 2 багийн судалгаа ирсэн байна.
116	Брошур тараах	Байгаль орчны улсын байцаагч Ж.Батзориг зорилтот жилийн хүрээнд төвийн бүх өрхүүдээр орж шаардлага хүргүүлж байгаа. Энэ үйл ажиллагаатай давхцуулан ХХХБ-аас гаргасан “Хүүхдээ түлэгдэх эрсдэлээс сэргийлье” сэдэвт брошурыг бүх айл өрхүүдэд тараалгасан.
117	Хүүхдийн төлөө зөвлөлөөр хуралдаж 2019 оны жилийн төлөвлөгөөг гаргах	ГБХЗХГ-аас 2019 оныг “Залуу гэр бүлийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан 2019-01-21нд Хүүхдийн төлөө зөвлөл 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж 2019 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөгөө гарган хэлтэс рүү хүргүүлсэн.
118	Эрх бүхий албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг үр дүнтэй хэрэгжүүлэх	2 хариутай албан бичиг дээр ажиллан хугацаанд нь явуулсан.
119	Орон нутагт гарсан кейс дээр ажиллах, шийдвэрлэх	Орон нутагт гарсан 2 кейсийг хааж, 1 кейс гарсан өрхөөр айлчилсан. Кейсийг ХХХБ-аар хэлэлцэн тухайн асуудалд холбоотой иргэнд хариуцлага тооцож дараагийн ХХХБ-н хурлаар шийдвэрлэлтийг хэлэлцээр тохирсон.
120	Зураг угаах, хэвлэх үйлчилгээ	7 иргэнийн цээж зургийг авч, 11 хувь угааж 9000 төгрөгийн үйлчилгээ хийгдсэн байна. Мөн тамгын газар дээр бүртгэлтэй байшингуудын зургийг хэвлэсэн. /нийт43 зураг/

121	Хүүхдээ ахуйн ослоос сэргийлье сарын аяны хүрээнд 0-5 настай хүүхэдтэй өрхөөр айлчлах	2019-01-18нд ЭМТ-ийн НЭМАжилтан Г.Ууганзаяатай хамт 0-5 настай хүүхэдтэй 7 өрхөөр айлчилж зөвлөмж өгөхийн зэрэгцээ гарын авлага тараасан.	
Багуудад хийгдсэн ажил үйлчилгээ			
122		Цэргийн тоо бүртгэлд эрчүүдээ хамруулсан.	
123		Багийн иргэдэд албан тоот гаргаж өгч үйлчилсэн.	
124		Улс, аймаг, сумын аварга малчдын материалыг бүрдүүлж холбогдох газарт хүргүүлсэн.Нийтдээ сумын хэмжээнд улсын аварга малчин 1, аймгийн аварга малчин 3, Алтан унаганы эзэн 1, сумын сайн малчин 7, аймгийн алдарт уяач 1, сумын алдарт уяач 5 тус тус шалгарсан.	
125		Арьс, ширний падан тушаахтай холбогдуулан малчдад мэдээлэл хийж, падануудыг сумын МЭҮТасагт хүргүүлсэн.	
126		Бэлэг авах ахмад настны судалгаа болон харъяалалгүй ахмадын судалгааг гаргаж ХХҮГазарт хүргүүлсэн.	
127		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгааг маягтын дагуу гаргаж хүргүүлсэн.	
128		Отроор өвөлжиж буй малчдын судалгааг гаргаж МЭҮТасагт хүргүүлсэн.	
129		Суманд шинээр гаргах инженерийн хийцтэй худгийн судалгааг гаргаж МЭҮТасагт хүргүүлсэн.	

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР